



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 27 өдөр

Дугаар А/65

Шивээговь сум

Мэргэжилтний баг ажиллуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1.4, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Иргэдийн сайн дурын үндсэн дээр байгуулагдах архинд донтох өвчнийг эдгэрүүлэх болон гэр бүлийн бусад гишүүдийг эдгэрүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй АА (архичид аминчлахуй) болон Ал-Анон (давхар хамаарлын бүлэг), Алатен (давхар хамааралтай хүүхдүүдийн бүлэг), АСА (архичдын болон асуудалтай гэр бүлд өссөн насанд хүрсэн хүмүүсийн бүлэг) нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих багийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Багийн ахлагч:

(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

(1 дүгээр багийн Засаг дарга)

(2 дугаар багийн Засаг дарга)

(1 дүгээр багийн эмч)

(2 дугаар багийн эмч)

(Цагдаагийн хэсгийн төлөөлөгч)

Нарийн бичгийн дарга:

(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

2. Архинаас ангижрахуй бүлэг болон үйл ажиллагаа явуулж буй бусад бүлгүүдийн нөхцөл байдлыг сайжруулах, шинээр үүсэн бий болж байгаа бүлгүүдийг бодлогын хүрээнд дэмжиж ажиллахыг (Мэргэжилтний баг)-т тус үүрэг болгосугай.

3. Мэргэжилтний багийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг (Хууль, эрх зүйн мэргэжилтэн), (Багийн ахлагч) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П. ГАНЧИМЭГ